

ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР БАРАА ХУДАЛДАН АВАХ

САНАЛ АВАХ ХҮСЭЛТ (БСАХ)

- Төслийн нэр: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төсөл, Үе шат-1 (3099-MON)
- Санхүүжилтийн эх үүсвэр: Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл
- Гэрээний дугаар ба нэр: SHPM-2: Сэлбэ дулааны станцын ашиглалтын дунд оврын крантай ачааны автомашин ханган нийлүүлэх (1 ширхэг)
- Хүсэлтийг гаргасан огноо: 2021 оны 07 сарын 20-ны өдөр

Эрхэм Танаа:

1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр -1" (цаашид "Захиалагч" гэх) дараах нэрийн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэх үнийн санал танай аж ахуйн нэгжээс ирүүлэхийг үүгээр хүсч байна:

№	Бараа, бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Дунд оврын крантай ачааны автомашин	ш	1

Та энэхүү худалдан авах ажиллагааны гэрээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн компанитай хэрэв хамтран оролцож байгаа бол таны саналаас татгалзана.

Үнийн санал бэлтгэхэд зориулан шаардлагатай техникийн тодорхойлолт болон нийлүүлэх тоо хэмжээний талаарх мэдээллийг хавсаргав. (*Хавсралт 1-ээс техникийн тодорхойлолтыг үзнэ үү*)

2. Та энэхүү хүсэлтийн дагуу тухайн сонгосон **бүх бараанд** саналаа ирүүлэх ёстой. Үнийн саналыг бүх бараанд хамгийн сайн үнэлэгдсэн үнийг санал болгосон компанид гэрээний эрх олгоно.

3. Сүүлийн 2 жилд (2019, 2020) санал болгож буй бараа материалтай ижил төстэй нэгээс доошгүй гэрээт ажилд оролцсон байх бөгөөд үүнийг батлах гэрээний хуулбар болон бусад материалын хамт ирүүлнэ. (*Хавсралт 2-ын МАЯГТ 1-ийг бөглөнө үү*)

4. Бараа материалыг нийлүүлэхэд шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам, зээлжих эрхийн тодорхойлолт мөн бусад санхүүжилтийн эх үүсвэрийг (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) олж авах эрхтэй, эсхүл авах боломжтой гэдгээ илтгэн мэдээлэх шаардлагатай. Шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ **120.0 сая төгрөг байх** (*Хавсралт 2-ын МАЯГТ 2-ыг бөглөнө үү*)

5. Хавсралт саналын маягтын дагуу бэлтгэсэн таны санал нь гарын үсэг зурагдаж тамгалагдан, баталгаажуулсан байх ёстой бөгөөд PDF файл болгон цахимаар procurement@ub-subcenter.mn хаягаар илгээнэ. Нэмэлт мэдээллийг цахим хаягаар

болон мөн 7000-3099 утсаар авах боломжтой. Таны санал монгол хэл дээр үйлдэгдсэн байх ба санал болгосон бараа тус бүрт техникийн хангалттай баримт, каталог, бусад хэвлэмэл материал эсвэл хамаарал бүхий мэдээлэл, түүнчлэн Монгол улсад борлуулалтын дараах засвар, үйлчилгээ үзүүлэх компанийн нэр ба хаяг зэргийг гаргаж өгнө.

6. Үнийн саналыг хүлээн авах эцсийн хугацаа: **2021 оны 08-р сарын 03-ны өдрийн 15:00 цаг**

7. Та дээр дурдсан барааны саналыг зөвхөн нэг иж бүрдэл баримт болгон ирүүлнэ. Та саналаа арилдаггүй бэхээр бичих ёстой ба танай байгууллагын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулна. Таны саналын маягт гарын үсэггүй тохиолдолд, саналыг тань үнэлгээнд харгалзахгүй болохыг анхаарна уу.

8. Та саналаа дараах заавар болон гэрээний маягтын дагуу ирүүлнэ. Гэрээнд хавсаргасан нийлүүлэлтийн нөхцөл шаардлага нь гэрээний салшгүй хэсэг болно.

(i) ҮНЭ: _____ (тоогоор, үсгээр) төгрөгийн үнэ бүхий барааг нийлүүлэх болон хүргэх зардлыг багтаана. Бараа хүргэх эцсийн цэг: *Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу 1, Амарын гудамж-2, Соёлын төв өргөө, Г-корпус, УБГХХХОДХТ*

(ii) САНАЛЫГ ҮНЭЛЭХ: Техникийн тодорхойлолтыг (Хавсралт 1) үндсэнд нь хангаж буй саналуудын үнийг хооронд нь харьцуулах замаар үнэлнэ. Хэрэв тухайн санал нь том зөрүү агуулсан, эсвэл санал авах хүсэлтэд заасан нөхцөл, шаардлага, тодорхойлолтын хувьд болзолт нөхцөлийг шаардсан бол ийм саналыг үндсэндээ шаардлагад нийцэхгүй гэж үзэж, түүнийг цаашид үнэлгээнд харгалзахгүй. Захиалагч зөвхөн үндсэндээ шаардлагад нийцсэн саналуудыг үнэлж харьцуулна. Захиалагч саналуудыг үнэлэхдээ, тооцооллын алдааг дараах байдлаар залруулна:

(a) тоогоор болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрүүтэй бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэх;

(b) нэгж үнийг тоогоор үржүүлсэнтэй холбоотойгоор нэгж үнэ ба нийт үнийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлах; ба

(c) нийлүүлэгч арифметик залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, түүний саналаас татгалзана.

Санал болгосон үнээс гадна, үнэлэгдсэн үнэд Монгол улсад мөрдөж байгаа дотоодын зах зээлийн нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг тусад нь тодорхой салгаж оруулна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Сангийн яамны НӨАТ-аас чөлөөлөгдсөн байгууллагуудын жагсаалтанд багтсан ба Захиалагчаас барааны үнийг төлбөрийг шилжүүлэхдээ НӨАТ-гүй дүнгээр тооцоо хийнэ.

(iii) ХУДАЛДАН АВАХ ЗАХИАЛГЫН ЭРХ: Гэрээний эрхийг хамгийн сайн үнэлэгдсэн үнийг санал болгосон, техникийн ба санхүүгийн чадварын шаардсан жишгийг хангаж байгаа ханган нийлүүлэгчид олгоно. Шалгарсан тендерт оролцогч хавсралтад байгаа гэрээний маягт болон нийлүүлэлтийн нөхцөл шаардлагад заасны дагуу гэрээнд гарын үсэг зурна.

(iv) САНАЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА: Таны санал энэхүү санал авах хүсэлтийн 7 дугаар заалтад дурдсаны дагуу санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 60 хоногийн туршид хүчинтэй байна.

(v) Хэрэв та тендерийн хүчинтэй хугацаанд өөрийн саналаа буцааж авах ба/эсвэл гэрээний эрх олгогдсон байхад гэрээний эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал таныг хоёр жилийн хугацаанд тухайн төслийн ханган нийлүүлэгчдийн жагсаалтаас Захиалагчийн зүгээс хасах эрхтэй болохыг анхаарна уу.


9. Захиалагч санал ирүүлэх хугацаанаас хойш **60** хоногийн дотор санал нь хүлээн зөвшөөрөгдсөн тендерт оролцогчид зөвшөөрлийн захидлыг илгээж, гэрээний эрх олгосон тухай мэдэгдэнэ.

10. Захиалагч нь энэхүү санал авах хүсэлтийн үр дүнд хийгдсэн худалдан авах захиалгын хүрээнд хийгдэх эрх бүхий төлбөрт Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг хэрэглэнэ.

11. АХБ-ны авлигын эсрэг бодлогын дагуу, тендерт оролцогч худалдан авах ажиллагаа болон түүнээс үүдэн гарах гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Хэрэв гэрээний эрх авсан тендерт оролцогч эсвэл аливаа этгээд тендерт өрсөлдөх эсвэл гэрээг хэрэгжүүлэх үед авилгал, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах эсвэл дарамт шахалт үзүүлэх үйлдэлд оролцсон нь тогтоогдвол АХБ гэрээний эрх олгох саналаас татгалзаж, үүнд холбогдсон этгээдэд хориг тогтооно. Саналаа ирүүлэх өдөр болон түүнээс өмнө, танай байгууллага нь АХБ-ны хориг жагсаалтанд ороогүй байвал зохино.

12. Та факсаар/цахим шуудангаар энэхүү хүсэлтийг авсан тухай болон үнийн санал ирүүлэх эсэхээ 2021 оны 7-р сарын 22-ны дотор дээрх 5-р хэсэгт заасан цахим шуудангаар мэдэгдэнэ үү.

Хүндэтгэсэн,



Д.Авирмэд, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн зохицуулагч

САНАЛЫН МАЯГТ

Хэнд: _____ (Захиалагчийн нэр)

_____ (Захиалагчийн хаяг)

Бид _____ (гэрээний нэр ба дугаар)-г гэрээний нөхцөлийн дагуу _____ (үнийн дүнг үсэг ба тоогоор илэрхийлэх) _____ (мөнгөн тэмдэгтийн нэр) гэрээний үнийн энэхүү саналын дагуу хэрэгжүүлэхээр санал болгож байна. Бид гэрээнд дурдсан барааг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш дор дурдсан нийлүүлэлтийн хугацаанд багтаан хүргэж дуусгах саналтай байна.

Нийлүүлэх үнэ ба хуваарь

#. Барааны нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ	Нийлүүлэх хугацаа
----------------	------------	----------	----------	-------------------

1.

2.

Сэлбэг хэрэгсэл

}

Дагалдах/нэмэлт хэрэгсэл

}

Гарын авлага

}

Засварын шаардлага

}

Шаардлагатай бол дурдах.

Энэ санал болон таны бичгээр үйлдсэн зөвшөөрөл нь бидний хооронд байгуулах гэрээний салшгүй хэсэг байх болно. Хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер болон бусад хүлээн авсан тендерийг та хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээгээгүй гэдгийг бид ойлгож байна.

Энэ санал нь санал авах хүсэлтийн баримт, нийлүүлэлтийн нөхцөл шаардлагад тус тус заасан саналын хүчинтэй хугацаа ба баталгаат хугацааны нөхцөлд нийцэж байгааг бид үүгээр баталгаажуулж байна.

Бид энэхүү санал авах хүсэлттэй уялдсан гэрээний зураг төсөл, тодорхойлолтыг бэлтгэсэн компанитай хамтран оролцоогүй болно.

Бид АХБ-ны хориг жагсаалтанд ороогүй болно.

Эрх бүхий гарын үсэг: _____

Гарын үсэг зурах этгээдийн нэр ба албан тушаал: _____

Нийлүүлэгчийн нэр: _____

Хаяг: _____

Утасны дугаар: _____

Факсын дугаар, шаардлагатай бол: _____

Цахим шуудан хаяг (шаардлагатай бол): _____

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

_____ дугаартай ЭНЭ ГЭРЭЭГ 202_ оны ____ дүгээр сарын ____-ний өдөр нэг талаас _____ (цаашид “захиалагч” гэх) ба нөгөө талаас _____ (цаашид “нийлүүлэгч” гэх) нар байгуулав.

Захиалагч _____ (цаашид “гэрээ” гэх)-ний дагуу нийлүүлэгчээс _____ (барааны нэр) нийлүүлэх саналыг хүссэн ба энэхүү гэрээний хүрээнд _____ (цаашид “гэрээний үнэ” гэх) үнэ бүхий барааг нийлүүлэх нийлүүлэгчийн саналыг хүлээн зөвшөөрсөн.

ЭНЭХҮҮ ГЭРЭЭГЭЭР ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ГЭРЧИЛНЭ:

1. Дараах бичиг баримтууд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно:
 - а) Саналын маягт; нийлүүлэлтийн нөхцөл ба шаардлага, техникийн тодорхойлолт;
 - б) Нэмэлт өөрчлөлт (хэрэв шаардлагатай бол);
2. Цаашид дурдсаны дагуу захиалагчаас нийлүүлэгчид хийх төлбөрийг үндэслэн, нийлүүлэгч нь энэ гэрээний хүрээнд барааг нийлүүлэх үүргийг гүйцэтгэж дуусгах, энэхүү гэрээний бүх нөхцөлд нийцүүлэн аливаа гэмтэл согог арилгах зорилгоор захиалагчтай энэхүү гэрээг үүгээр байгуулав.
3. Захиалагч нь гэрээг хүлээн зөвшөөрсөн байдал, барааг нийлүүлж хүргэх нөхцөл, болон гэмтэл согог арилгах үйлчилгээ зэргийг үндэслэн гэрээний үнийг гэрээнд тодорхойлсон төлбөрийн нөхцлийн дагуу төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

Талууд энэхүү гэрээг _____ (захиалагчийн улс) улсын хуулийн хүрээнд дээр дурдсан өдөр үүгээр байгуулав.

Захиалагчийн гарын үсэг ба тамга:
Захиалагчийг төлөөлж

Нийлүүлэгчийн гарын үсэг ба тамга:
Нийлүүлэгчийг төлөөлж

Эрх бүхий төлөөлөгчийн нэр

Эрх бүхий төлөөлөгчийн нэр

НИЙЛҮҮЛЭЛТИЙН НӨХЦӨЛ БА ШААРДЛАГА

Төслийн нэр: Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр, Үе шат 1 (3099-MON)

Захиалагч: Нийслэлийн Засаг даргын Тамгын Газар

Тендерийн дугаар ба нэр: SHPM-2: Сэлбэ дулааны станцын ашиглалтын дунд оврын крантай ачааны автомашин ханган нийлүүлэх

1. Нийлүүлэх хуваарь

#	Барааны нэр	Тоо ширхэг	Нийлүүлэх хугацаа
1.			
2.			
	<u>Сэлбэг хэрэгсэл</u>	}	
	<u>Дагалдах/нэмэлт хэрэгсэл</u>	}	
	<u>Гарын авлага</u>	}	Шаардлагатай бол дурдах.
	<u>Засварын шаардлага</u>	}	
 2. Тогтмол үнэ: Саналын маягтанд заасан үнэ нь тогтмол байх ба гэрээний хэрэгжилтийн явцад түүнд ямар нэгэн залруулга өөрчлөлт үл оруулна.
 3. Нийлүүлж хүргэх хуваарь: Нийлүүлэлтийг дээрх хуваарийн дагуу, гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс **60 хоногийн** дотор хийж дуусгана.
 4. Даатгал: Гэрээний хүрээнд нийлүүлэх барааг үйлдвэрлэх, эсвэл худалдан авах, тээвэрлэх, хадгалах ба хүргэхтэй холбоотойгоор гарах аливаа алдагдал, хохирлоос хамгаалах үүднээс чөлөөтэй хөрвөх мөнгөн тэмдэгтээр бүрэн даатгуулна. Даатгалын хэмжээ нь “бүх эрсдэлээс хамгаалах” нөхцөлийн дагуу барааны үнийн 110 хувьтай тэнцүү байх ёстой.
 5. Мөрдөх хууль: Гэрээг захиалагчийн улсын хуулийн дагуу хэрэгжүүлнэ.
 6. Маргаан шийдвэрлэх: Захиалагч ба нийлүүлэгч нь тэдгээрийн хооронд гэрээтэй холбогдон гарч болох аливаа үл тохиролцол эсвэл маргааныг албан бус, шууд хэлэлцээрээр зөвшилцөн шийдэхийг хичээнэ. Захиалагч ба нийлүүлэгчийн хооронд маргаан үүссэн тохиолдолд, уг маргааныг захиалагчийн улсын арбитрын хууль дүрмийн заалтын дагуу шийдвэрлэнэ.
 7. Барааны нийлүүлэлт ба холбогдох бичиг баримт: Нийлүүлэгч барааг нийлүүлэхдээ дараах баримтуудыг захиалагчид гаргаж өгнө:
 - (i) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
 - (ii) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж үнэ болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хуулбар;
 - (iii) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ; ба
 - (iv) Барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Хэрэв барааг буухиа шуудангаар илгээх тохиолдолд барааг хүлээн авах захиалагчийн нөхцөлийг хангах үүднээс нийлүүлэгч баримтуудын хуулбарыг бараа нийлүүлэхээс өмнө гаргаж өгнө. Захиалагч дээрх баримтуудыг бараа ирэх өдрөөс 1-ээс доошгүй долоо хоногийн өмнө хүлээн авсан байна. Хэрэв баримтыг хүлээн аваагүй бол нийлүүлэгч үүнтэй уялдан гарах аливаа зардлыг хариуцна.
8. Төлбөр: Гэрээний үнийн төлбөрийг дараах нөхцөлийн дагуу гүйцэтгэнэ:

- Гэрээний нөхцөлийн дагуу нийлүүлсэн барааг Захиалагчид хүлээлгэн өгсөн болон
 - Захиалагч нь зохих нэхэмжлэх болон бусад дагалдах баримт бичиг хүлээн авсан нөхцөлд 100 хувь.
9. Чанарын баталгаа: Санал болгосон бараа нь захиалагчид нийлүүлсэн өдрөөс хойш 1 жилээс багагүй (5000 км), үйлдвэрлэгчийн чанарын баталгаатай байна.
10. Гэмтэл согог: Нийлүүлэгч бүх гэмтэл согогийг захиалагчаас мэдэгдэл авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор баталгаат хугацааны эсвэл заасан км-т шинэ крантай ачааны автомашинаар захиалагчаас ямар нэгэн зардал гаргахгүйгээр сольж өгнө.
Баталгаат хугацаанд нийлүүлэгчээс гэмтэл согогийг засварлах газрын нэр хаяг:
- Газар: _____
- Хаяг: _____
11. Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл: Хэрэв гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний хүрээнд ажлын гүйцэтгэл удааширсан эсхүл гэрээний үүргийг биелүүлэх явцад аливаа алдаа гарсан тохиолдолд нийлүүлэгч торгууль эсхүл гэрээг цуцалсан асуудлыг хариуцахгүй.
- Энэ зүйлийг тодруулах зорилгоор, “гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйл” гэдэг нь нийлүүлэгчийн хяналтаас гадуур, бөгөөд нийлүүлэгчийн алдаа эсхүл хайхрамжгүй байдлаас ангид, ба урьдчилан харах боломжгүй үйл явдлыг хэлнэ. Ийм үйл явдалд дайн, эсвэл хувьсгал, гал түймэр, үер, халдварт өвчин, хорио цээр, ба ачаа тээврийн хориг орж болох бөгөөд энэ нь нийлүүлэгчийн бие даасан чадамжийн хүрээнд түүний үйлдлээр хязгаарлагдахгүй болно.
- Гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол нийлүүлэгч гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн ба давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайж олно.
12. Шаардлагатай техникийн тодорхойлолт: (шаардлагатай бол хавсралтаар гаргаж бэлтгэх)
- (i) Ерөнхий тойм
 - (ii) Онцлог нарийн болон техникийн жишиг үзүүлэлтүүд
 - (iii) Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд
- Нийлүүлэгч дээр дурдсан үзүүлэлтүүдэд нийцэж байгааг үүгээр баталж байна.
13. Үл биелүүлэх: Хэрэв нийлүүлэгч дээр дурдсан нөхцөл шаардлагын дагуу барааг хүргэж чадаагүй тохиолдолд захиалагч 14 өдрийн мэдэгдэл хүргэхгүйгээр, нийлүүлэгчид аливаа үүрэг хариуцлага ногдуулахгүйгээр гэрээг цуцалж болно.
- Нийлүүлэгчийн нэр: _____
- Эрх бүхий гарын үсэг: _____
- Газар: _____
- Огноо: _____

ХАВСРАЛТ 1.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Ерөнхий шаардлага:

- Санал болгож буй дунд оврын крантай ачааны автомашиныг үйлдвэрлэгч нь Монгол улсад нийлүүлэх албан ёсны борлуулагч байна.
- Крантай ачааны автомашин нь Монгол орны уур амьсгалд тохирсон, үндсэн тоноглол, хэрэгслээр бүрэн тоноглогдсон байна.
- Крантай ачааны автомашиныг дагалдах бичиг баримт (техникийн паспорт, катологи, сертификат,бусад) бүрэн, техникийн зохих үйлчилгээ хийгдсэн, энэ тухай тодорхойлолттой байх
- Нийлүүлэх бараа нь холбогдох стандартын шаардлага хангасан байх бөгөөд техникийн үзүүлэлт болон бусад тайлбар, танилцуулгыг хавсаргаж ирүүлнэ.

ЗАХИАЛАГЧИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ			ЭРХ БҮХИЙ ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН ТЕХНИКИЙН САНАЛ	
Но.:	Барааны нэр:	Тоо хэмжээ:	Үйлдвэрлэгч:	
1	Дунд оврын крантай ачааны автомашин	1	Загвар:	Нэмэлт бичиг баримтууд: (Брошур, каталогууд, зурагнууд г.м)
Шаардлагатай техникийн тодорхойлолт			Санал болгож буй техникийн тодорхойлолт	Нэмэлт мэдээлэл
Ерөнхий мэдээлэл Үйлдвэрлэсэн он 2020 Төрөл Өөр дээрээ крантай тэвштэй ачааны автомашин Баталгаат хугацаа 1жил Баталгаат км 5000км Явах эд анги Хөдөлгүүрийн төрөл Дизель түлш Цилиндрийн багтаамж 6500сс-ээс багагүй Хурдны хайрцаг Механик Хөтлөгч тэнхлэг Хойд Жолооны хүрд Зүүн Шатахуун				

Шатахууны төрөл	Дизель		
Шатахууны савны багтаамж	200литрээс багагүй		
Овор хэмжээ			
Тэвшний даац, тн	8тн		
Краны даац, тн	3-5тон 3 сумтай		
Тулах хөл	4 ширхэг		
Тэвшний хэмжээ	6000мм хүртэл		
Газраас тэнхлэг хүртэлх зай	300мм-ээс багагүй		
Дугуй			
Нөөц дугуй	1 ширхэг		
Тоноглол			
Салоны халаагч систем	Стандартаар		
Агааржуулалтын систем	Стандартаар		
Манангийн гэрэл	Стандартаар		
Цонх автоматаар өргөгч	Стандартаар		
Урд хойноо нумтай эсэх	Тийм		
Дагалдах хэрэгсэл			
Багажны ком	Түлхүүр – 1ком, Дугуйн торцов – 1ш, Домкрат -1ш		
Гал унтраагуур	2ш		
Гурвалжин тэмдэг	1ш		
Эмийн сан	1ш		
Гарын авлага	1ш		

ХАВСРАЛТ 2(а)**Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага - Маягт 1**

Гэрээний дугаар:	Гэрээний нэр:
Гэрээ байгуулсан огноо:.....	Гэрээний нийт дүн: төгрөг
Гэрээ дуусгавар болсон огноо:.....	
Ханган нийлүүлсэн барааны тодорхойлолт, нэр төрөл, тоо ширхэг	- - - - -
Захиалагчийн нэр: Холбогдох хүн: Хаяг: Утас/Факс: Цахим хаяг:	

Санхүүгийн чадавхи - Маягт 2

Бараа материалыг нийлүүлэхэд шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам, зээлжих эрхийн тодорхойлолт мөн бусад санхүүжилтийн эх үүсвэрийг (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) олж авах эрхтэй, эсхүл авах боломжтой гэдгээ илтгэн мэдээлэх шаардлагатай. Шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ 120.0 сая төгрөг байна.

Санхүүгийн эх үүсвэр	Дүн
1.	
2.	
3.	
4.	